

## 01 дугаар сард зохион байгуулсан ажлын тайлан

---

**Хүнсний үйлдвэрлэлийн салбар:** Үйл ажиллагаа явуулж байгаа гурилын үйлдвэрүүдээс “Улаанбуудайн үлдэгдэл, гурил үйлдвэрлэлт, борлуулалтын үнийн судалгаа”-г тогтмол авч, ҮХААЯ-д хүргүүлж байна. 2014.12.31-ний байдлаар 1 кг дээд гурил БГ055-980 төг, 1-р гурил БГ085 -770-780 төг, 2-р гурил БГ115 -400-510 төг, хивэгний үнэ 370-380 төгрөгний үнэтэй байна

Хүнсний боловсруулах үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг махны 7, сүүний 12 үйлдвэрийн судалгааг гаргаж, АЗДТГ-т, Сүү боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг нэр төрлөөр нь, түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний агуулахын судалгааг гаргаж, ҮХААЯ-д тус тус хүргүүлсэн байна.

ХЭАХН-тэй хамтран ажиллаж, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Дельба ХХК, Грөв, Арвижих-Ундрах ХХК, Жаргал кафе, Беад, Хаан зоог, Дэлгэрэх, Хилэнц, Тэнгис рестораны нийт 9 байгууллагын 34 тогооч нарт 1-р сарын 17-д сургалт зохион байгуулж, хууль эрхзүйн мэдлэгийг олгосон байна.

Европын холбоо Монгол улсын засгийн газартай хамтран ажиллах гэрээ байгуулсантай холбогдуулан төслийн баримт бичиг боловсруулах ажлын баг Дархан-Уул аймагт ажиллаж, Дархан meat фүүдс ХХК, Дархан нэхий ХХК, Дархан минж ХХК, УГТЭШХ, Таван од цех зэрэг 5 байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, санал солилцлоо.

**Мал аж ахуйн салбар:** Аймгийн Засаг даргын орлогчийн Мал аж ахуйн өвөлжилтийн цаг үеийн явцтай танилцах ажлын удирдамжийн дагуу Хөгжлийн бодлогын хэлтэс, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Онцгой байдлын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Сумдын ЗДТГ-тай хамтарсан ажлын хэсэг хөдөө 5 хоног ажиллалаа. Уг өвөлжилтийн цаг үеийн талаар орон нутгийн ЛХА, RGB телевизүүдээр мэдээлэл хийгдэж, Монос эмийн сангийн явуулын үйлчилгээ малчдад үзүүллээ.

Шарын гол сумын Санжинт багийн малчин Лхагва овогтой Цэвээнийг “Улсын Сайн малчин”-аар, МҮОНРадиогийн Нийгэм, Хөдөө аж ахуйн редакци, Хүнс, хөдөө аж ахуйн яам хамтарсан “Таван эрдэнэ” нэвтрүүлгийн нэрэмжит шагнал болох “Алтан төлийн эзэн” шагналд Хонгор сумын 2 дугаар багийн малчин Тэгшсамбуу овогтой Эрдэнэсүрэнг “Алтан тугал”-ын эзэнд тус тус тодорхойлон материалыг ХХААЯ-ны МААБХЗГ-т хүргүүлсэн байна.

Хонгор сумын малчин Н.Батхуяг, Ж.Ганхуяг, Дархан сумын малчин Ц.Нэмэхжаргал, Орхон сумын малчин Н.Ганхуяг, М.Цэцэгмаа нарыг Аймгийн сайн малчин-аар шагнуулахаар материалыг Аймгийн ХБХ-т хүргүүллээ.

“Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд урамшуулал олгох журам”-ын дагуу Сумдын 2014 оны сүүлийн хагас жилийн арьс, ширний урамшуулалд 562 хоршооны гишүүн малчдын 1913 падааныг хүлээн авч “Цахим програм”-д оруулах ажил хийгдэж байна,

Аймгийн хэмжээнд сүү, махны 55, махны хонь 2, гахай 9, тахиа 9, туулай 1, зөгий 5 фермер үйл ажиллагаа явуулж байна. Уг судалгаанд бүдүүн, бүдүүвтэр ноост хонь үржүүлэгчдийн судалгаа ороогүй болно.

Мал аж ахуйн хэлтсийн 2014 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, мал үржлийн тайланг холбогдох маягт, хүснэгтийн дагуу гаргаж МЭҮГ-т хүргүүллээ.

**Мал эмнэлэг:**

2014 оны Мал эмнэлгийн арга хэмжээний жилийн эцсийн мэдээг 18 маягтаар гарган, тайланг МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Мал эмнэлэг үржлийн газар болон ҮХААЯ-ны Хяналт шинжилгээ, үнэлгээний газарт хүргүүлэв. Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги бүлгийн хүч, хэрэгслийн судалгааг шинэчлэхтэй холбогдуулж Хүнс, Хөдөө аж ахуйн мэргэжлийн ангийн хүч, хэрэгслийн судалгааг гарган аймгийн Онцгой байдлын газарт албан тоотоор хүргүүлэв. 2014 онд хэлтэст ирсэн албан бичгүүд болон орон нутгийн МЭҮТасаг болон нэгжүүдээс ирүүлсэн мэдээ тайлан, акт баримтуудыг үдэж, цэгцлэн архивт хүлээлгэж өгөхөөр бэлэн болгов. 2015 оны ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулав. 2015 онд Мал эмнэлгийн нэгжүүд болон МЭҮТасгуудтай хийх 2015 оны Үр дүнгийн гэрээний төслийг шинэчлэн боловсруулав. Орон нутагт мал эмнэлгийн ажил үйлчилгээ эрхэлж байгаа анхан шатны Мал эмнэлгийн нэгжүүдийн 2014 оны ажлыг 14 үзүүлэлтээр тус бүр гарган үр дүнгийн гэрээг дүгнэв.

**Жич: Шинэлэг ажил:**

Монголын залуучуудын холбооны нэрэмжит шагнал болох “Шилдэг залуу малчин”-аар Шарын гол сумын Жамъян овогтой Бямбажав шагнагдлаа..

**Тулгамдаж буй ажил:**

“Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд урамшуулал олгох журам”-ын дагуу 2013 онд Монгол банкнаас “Малчин” дансаар олгож байгаад програмын гэмтлээс болон үлдсэн 4 сумын 57 малчдын нэрсийн жагсаалтыг нэгтгэж МХСанд хүргүүлсэн байна.

**БАТЛАВ: ГАЗРЫН ДАРГА...../Ц.ЭНХЖАРГАЛ /**

**ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН  
2015 ОНЫ 02 ДУГААР САРД ЗОХИОН БАЙГУУЛАХ  
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хийгдэх ажил	Огноо	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
<b>Мал аж ахуйн хэлтэс</b>				
1	Аймгийн мал зүйчдын уулзалт зохион байгуулах	2 дугаар сарын 13	МААХ	МЭҮТ-ийн ажлыг дүгнэсэн байна.
2	Арьс, ширний урамшуулалын тайланг МХС-нд хүргүүлэх	2 дугаар сарын 15	Д.Амарсоёл	Тайланг үнэн зөв гаргасан байна.
3	Том малын зүй бусын хорогдлын мэдээг авч нэгтгэх	2 дугаар сарын 20	С.Баасан	Тайланг үнэн зөв гаргасан байна.
4	Малын ээмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлтийн мэдээ	2 дугаар сарын 25	С.Баасан	Тайланг үнэн зөв гаргасан байна.
5	Арьс, шир Ноосны урамшуулал малчдад олгох ажлыг зохион байгуулах, хяналт тавих	2 дугаар сарын 28	С.Баасан Д.Амарсоёл	Сумдын МЭҮТ-тай хамтран зохион байгуулсан байна.
<b>Мал эмнэлгийн хэлтэс</b>				

7	2015 оны ажлын төлөвлөгөөг календарчилсан самбарт зүүх	Сардаа	Н.Баасансүрэн	Ажлын бүтээмж дээшилнэ.
8	2015 оны Мал эмнэлгийн арга хэмжээнд хамрагдах мал, түүнд шаардагдах эм бэлдмэлийн захиалгад тухайн онд ИТХ-аар батлагдсан үйлчилгээний хөлсний төсөвт багтаан өөрчлөлт оруулж МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг МЭҮГазарт албан тоотоор хүргэх	Сардаа	Х.Хавсамет	Тухайн онд шаардлагатай эм бэлдмэлийг захиалсан байна.
9	Аймгийн ИТХ-ын байнгын хорооны төлөөлөгчид тус газрын ажил байдалтай танилцахтай холбогдуулан МЭХ-ийн болон Мал эмнэлгийн арга хэмжээ, үр дүнгийн талаар мэдээлэл бэлтгэх	2-р сарын 6	Х.Хавсамет	Салбарын мэдээллээр хангасан байна.
10	2016 онд Мал эмнэлгийн арга хэмжээнд хамрагдах мал, түүнд шаардагдах эм бэлдмэлийн захиалгыг холбогдох маягтаар нь гарган, аймгийн Засаг даргаар батлуулах	2-р сарын 20-ны дотор	Х.Хавсамет	Шаардлагатай эм бэлдмэлийн тоо хэмжээг батлуулсан байна.
11	2015 онд хийгдэх эм, вакциныг татан авах талаар Биокомбинат төрийн өмчит үйлдвэрийн газартай тохиролцох	Сардаа	Х.Хавсамет	Эм, вакцинаар хангагдана.
<b>Үйлдвэр, газар тариалангийн хэлтэс</b>				
1	Гурилын үйлдвэрээс “Улаанбуудайн үлдэгдэл, гурил үйлдвэрлэлт, борлуулалтын үнийн судалгаа” гаргаж, ҮХААЯ-д хүргэх	I/31, II/15	Г.Тунгалаг	Албан тоотын хариуг хугацаанд нь гаргаж, мэдээг хүргэсэн байна.
2	2015 онд нийлүүлэх нөөцийн махны борлуулалтын ажлыг зохицуулах	II	Г.Тунгалаг	Мах борлуулах хуваарь гаргасан байна.
3	Цагаан сар -2015 үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлын хэсэгт ажиллах	II/6-9	Г.Тунгалаг	Бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилсан байна.
4	ЕБС-ийн 1-5-р ангийн хүүхдийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг тооцож, бодит гүйцэтгэлтэй харьцуулах	I/27- II/5	Г.Тунгалаг	Техникийн тодорхойлолт гаргахад үндсэлэл болно.
5	2015 онд хүнсний салбарт хэрэгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөө боловсруулах	I/31	Г.Тунгалаг	Төлөвлөгөө гарсан байна.

Төлөвлөгөөг нэгтгэсэн: Бичиг хэрэг, архивын эрхлэгч ..... Д.Баярмаа

Төлөвлөгөөг хянасан: ЗУХэлтсийн дарга ..... Б.Бат-Эрдэнэ